

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны тайлан

ТУЗ-ийн бүрэлдэхүүний талаар

Хувьцаа эзэмшигчдийн хурлын эзгүйд компанийн бизнесийн үйл ажиллагааг удирдан явуулахтай холбоотой асуудлыг шийдвэрлэх компанийн эрх барих байгууллага нь Төлөөлөн удирдах зөвлөл байдаг. Төлөөлөн удирдах зөвлөл нь 9 гишүүнтэй, тэдгээрийн гуравны нэг (1/3) хараат бус гишүүн бөгөөд ердийн 6 гишүүн нь төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлдэг.

Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2023 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийг чөлөөлж, сонгосон билээ. ТУЗ-ийн ердийн гишүүн Эрдэнэбулган өөрийн хүсэлтээр, ердийн гишүүн Т.Лхагвасүрэн өөр ажилд шилжин ажиллах болсон шалтгаанаар тус тус чөлөөлөгдөж, ТУЗ-өөс Б.Төрбат, Ц.Баяр-Эрдэнэ нарыг ТУЗ-ийн ердийн гишүүнээр түр томилж 2023 оны 10 сарын 09-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар Б.Төрбат, Ц.Баяр-Эрдэнэ нарыг ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгосон. 2023 оны 12 сарын 31-ний байдлаар Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд ердийн гишүүнээр ТУЗ-ийн дарга Ц.Баяр-Эрдэнэ, Ж.Цогтбаяр, Ч.Цэвэгдорж, М.Лхагважав, А.Молор, Б.Төрбат, хараат бус гишүүн Ц.Норовжамц, С.Цолмон, Х.Баянбай нар ажилласан.

Хурлын мэдээлэл

Төлөөлөн удирдах зөвлөл нь жил бүрийн эхний улиралд Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудлын ерөнхий төлөвлөгөөгөө батлан ажилладаг бөгөөд жилийн зардлын төсвийн төслийн саналаа Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлэн батлуулдаг.

2023 онд 9 удаагийн хурлаар 18 асуудал хэлэлцэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 15 удаа хуралдаж, 41 асуудал хэлэлцэж шийдвэр гаргасан байна. Нийт 7 удаагийн хурлыг танхимаар хуралдаж, зайнаас 5 удаа, танхим болон зайнаас хосолсон байдлаар 3 удаа хуралджээ. Төлөөлөн удирдах зөвлөлөөс нийт 34 тогтоол, 4 тэмдэглэл гарган хэрэгжилтийг хянаж ажиллалаа.

Хурлын ирц

2023 онд ТУЗ-ийн хурлын ирц 100 хувьтай, хурлаас чөлөө авсан, тасалсан гишүүд байгаагүй.

ТУЗ-ийн гишүүд	Хурлын дугаар															Гишүүний ирц
	185	186	187	188	189	190	191	192	193	194	195	196	197	198	199	
Г.Эрдэнэбулган	и	и	и	и	и	и	и									100%
Ж.Тамир	и	и	и	и	и	и										100%
Ж.Цогтбаяр	и	и	и	и	и	и	и	и	и	и	и	и	и	и	и	100%

Ч.Цэвэгдорж	и	и	и	и	и	и	и	и	и	и	и	и	и	и	и	и	100%
Т.Лхагвасүрэн	и	и	и	и	и	и	и	и									100%
Ц.Норовжамц	и	и	и	и	и	и	и	и	и	и	и	и	и	и	и	и	100%
М.Лхагважав	и	и	и	и	и	и	и	и	и	и	и	и	и	и	и	и	100%
Ю.Бат-Эрдэнэ	и	и	и	и	и	и											100%
А.Молор	и	и	и	и	и	и	и	и	и	и	и	и	и	и	и	и	100%
Х.Баянбай							и	и	и	и	и	и	и	и	и	и	100%
С.Цолмон							и	и	и	и	и	и	и	и	и	и	100%
Б.Төрбат								и	и	и	и	и	и	и	и	и	100%
Ц.Баяр-Эрдэнэ									и	и	и	и	и	и	и	и	100%
Хурлын ирл - 100%	100%	100%	100%	100%	100%	100%	100%	100%	100%	100%	100%	100%	100%	100%	100%	100%	

ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагаа

Төлөөлөн удирдах зөвлөл нь Аудитын хороо, Нэр дэвшүүлэх хороо, Цалин урамшууллын хороо гэсэн гурван хороотой.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны даргаар хараат бус гишүүн С.Цолмон, гишүүдээр ердийн гишүүн Ж.Цогтбаяр, хараат бус гишүүн Х.Баянбай нар; Нэр дэвшүүлэх хорооны даргаар хараат бус гишүүн Ц.Норовжамц, гишүүдээр ердийн гишүүн А.Молор, хараат бус гишүүн С.Цолмон, Цалин, урамшууллын хорооны даргаар хараат бус гишүүн Х.Баянбай, гишүүдээр ердийн гишүүн Б.Төрбат, хараат бус гишүүн Ц.Норовжамц нар тус тус ажиллаа.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Цалин, урамшууллын хороо хоёр удаа, Аудитын хороо 5 удаа, Нэр дэвшүүлэх хороо хоёр удаа тус тус хуралдаж санал, дүгнэлтээ боловсруулан Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулсан байна. Аудитын хороо 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гарган Төлөөлөн удирдах зөвлөл болон Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар танилцууллаа.

ТУЗ-ийн хэлэлцсэн онцлох асуудлуудаас

Компанийн засаглалыг сайжруулах, компанийн засаглалын кодексийг хэрэгжүүлэх, компанийн засаглалын журмуудыг шинээр болон шинэчлэн боловсруулж, баталлаа. “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ыг шинэчлэн баталж, ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагааны журам, хөрөнгө оруулагчтай хамтран ажиллах, мэдээллийн ил тод байдлын журам зэрэг нийт 15 журмыг шинээр баталсан байна.

Мөн компани нэмэлт хувьцаа гаргахтай холбоотой төлөвлөгөөг батлан гүйцэтгэлийн хянан компанийн нийтэд санал болгох хувьцааны үнийг тогтоох тухай, үнэт

цаасны танилцуулга болон хувьцааг нийтэд арилжаалах журмыг батлах тухай шийдвэрийг гаргалаа.

Төрийн өмчит болон өмчийн оролцоотой компаниудын засаглалын талаар олон улсын туршлага судлах зорилгоор ТУЗ-ийн нэг гишүүнээ сургалт, семинарт хамрууллаа.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны зардлын гүйцэтгэл

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны зардлын төсвийг 2023 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар 144.9 сая төгрөгөөр баталсан бөгөөд гүйцэтгэлээр 122.4 сая төгрөг буюу 84 хувийн гүйцэтгэлтэй, 22.5 сая төгрөг хэмнэсэн байна.

№	Төлөвлөгөө					Гүйцэтгэл	
	Зардлын төрөл	Тоо	Нэгж зардал	Давтамж	Нийт дүн	Гүйцэтгэл	Хувь
1. Цалин, холбоо, тээврийн зардал							
1	ТУЗ-ийн гишүүний цалин	9	900,000	12	97,200,000	97,200,000	100%
2	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	1	620,000	12	7,440,000	5,107,200	69%
3	ТУЗ-ийн нарийн бичгийн даргын холбооны зардал	1	150,000	12	1,800,000	1,800,000	100%
	Цалин, холбоо, тээврийн зардлын дүн				106,440,000	104,107,200	98%
4	Нийгмийн даатгалын шимтгэл				13,917,120	12,592,440	90%
	Дэд дүн				120,357,120	116,699,640	97%
2. Бичиг хэрэг, хурлын зардал							
1	Бичиг хэрэг, хэвлэмэл материал, цай, кофены зардал	1	150,000	12	1,800,000	1,800,000	100%
3	Хурал зохион байгуулах байрны түрээс	1	200,000	2	400,000		
4	Бусад зардал	1	110,000	5	500,000		
	Дэд дүн				2,700,000	1,800,000	67%
3. ХХМТ-ийн салбар болон дэд бүтэц, бусад холбогдох салбарын туршлага судлах, хурал, үзэсгэлэнд оролцох, сургалтын зардал							
1	Зөвлөх үйлчилгээ авах зардал	1	1,000,000	1	3,000,000		0%
2	Сургалтын зардал	8	550,000	1	4,400,000		0%
3	Тээврийн зардал	3	2,500,000	1	7,500,000	1,786,100	24%
4	Зам хоног /5 өдөр/	3	145,000	5	1,740,000	725,000	42%
5	Зочид буудал /5 өдөр/	3	435,000	5	5,220,000	1,740,000	33%
	Дэд дүн				21,860,000	4,251,100	19%
	Нийт дүн				144,917,120	122,750,740	85%